



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/76

Цагаан-Уул сум

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал амьтаны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.9.1, 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын Тосон багийн нутаг “Өвөр асгат” хэмээх газар хаваржиж байгаа малчин Э.Бямбадоржийн хонь өвчилж мал, амьтаны халдварт Листриоз өвчний сэжигтэй тохиолдол илэрч Аймгийн мал эмнэлэг, ариун цэврийн төв лаброторийн шинжилгээний №24-50 дүгнэлтээр мал амьтаны халдварт Листриоз өвчин болох нь тогтоогдсон тул тус багийн нутаг дэвсгэрт 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийг дуустал хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүс нутгаас амьд мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, өвс тэжээлийн тээвэрлэлт, малын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, хяналт тавьж ажиллахыг Багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Халдварт Листриоз өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, өвчний тархалтын тандалт судалгааг үргэлжлүүлэн хийх халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед холбогдох хариу арга хэмжээг авч мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж хяналт тавьж, явцыг тухайны бүр сумын Онцгой комисст танилцуулж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга Улсын байцаагч (Т.Чандмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГОНЧИГНЯМ

/Zahiramj 2024/